

**Улаанбаатар хотын Хөдөлмөрчдийн
депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа**

1940-10-3-анд Сайд нарын Зөвлөлийн 50-р хурлын 8-р зүйлээр Улаанбаатар хотын хөдөлмөрчин ардын хурал ба хотын захиргааны дүрмийг баталжээ.

Мөн дүрэмд хотын захиргааны дотоод зохион байгуулалтыг : - Санхүүгийн хэлтэс - Ардын гэгээрлийн хэлтэс - Эрүүлийг хамгаалах хэлтэс - Цэргийн хэлтэс - Хот сайжруулах хэлтэс - Аж ахуйн хэлтэс гэж тус тус байхаар тогтоожээ.

1953 онд Улаанбаатар хотын захиргааны зохион байгуулалт, орон тоо нь:

Ерөнхий хэлтэс 1- 42

Санхүүгийн хэлтэс 1- 26

Гэгээрлийн хэлтэс 1- 9

Төлөвлөгөөний комисс 1-19

Эрүүлийг хамгаалах хэлтэс 1-8

Цэргийн хэлтэс 1- 2

Хот сайжруулах 1- 23 Бүгд 7-123 тус тус байсан байна.

1952 оны 11 сарын 01-эс Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа - хэмээх болсон.

Бөгөөд дотоод бүтцийг нь : Бүгд 7-123 тус тус байсан байна.

1957-7-6-анд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 104-р зарлигаар үндсэн хуулийн зарим зүйлд өөрчлөлт оруулж аймгийн ба Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргаанд дор дурдсан хэлтсүүд байхаар тогтоожээ.

Үүнд:

- Төлөвлөгөөний хэлтэс
- Хөдөө аж ахуйн хэлтэс
- Зохион зааварлах хэлтэс
- Санхүүгийн хэлтэс
- Эрүүлийг хамгаалах хэлтэс
- Соёлын хэлтэс
- Гэгээрлийн хэлтэс
- Ерөнхий хэлтэс

1961-11-24-нд Сайд нарын Зөвлөлийн 601-р тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны соёлын хэлтэс, хөдөлмөрийн товчоо, тээврийн хэлтсийг татан буулгаж мөн захиргааны зохион байгуулалтыг:

- Хотын төлөвлөгөөний комисс
- Эрүүлийг хамгаалах газар
- Санхүүгийн хэлтэс
- Гэгээрлийн хэлтэс
- Цэргийн хэлтэс
- Зохион зааварлах хэлтэс
- Ерөнхий хэлтэс гэж баталсан.

1962 онд Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа хэмээх болсон.

БНМАУ-ын АИХ-ийн Тэргүүлэгчдээс 1965 оны 04 сарын 14-ний өдөр гаргасан 79 дүгээр зарлигаар хороодыг татан буулгаж, Улаанбаатар хотод Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдал, гэсэн 4 районыг байгуулсан.